

UCS 2101A:2023

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДЭГ




Гудамж, зам, барилга байгууламжийн хаягжилт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДЭГ

Гудамж, зам, барилга байгууламжийн
хаягжилт

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 38-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	4
4. Ерөнхий шаардлага.....	4
5. Нэрийн тэмдгийн бичвэрт тавигдах шаардлага	5
6. Төрийн байгууллагын ангилал	6
7. Нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө	6
8. Дээд газар, яамны нэрийн тэмдгийн бичвэр самбарын хэмжээ	7
9. Нийслэлийн нутгийн захиргааны болон түүний харьяа байгууллагууд	7
10. Дүүргийн засаг даргын тамгын газар	8
11. Материалын шаардлага	9
12. Байрлуулах	10
13. Суурилуулах	11
14. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийг хүлээн авах шалгуур үзүүлэлт	12
Ашигласан материалын жагсаалт	13

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг	5
Зураг 2. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн бичвэр.....	5
Зураг 3. Алтан шар нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ	7
Зураг 4. Хөх цэнхэр нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ	8
Зураг 5. Мөнгөлөг нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ	9
Зураг 6. Нэрийн тэмдгийн гадаргуугийн гэрлийг ойлгох чанар	10
Зураг 7. Төрийн байгууллагын нэрийн бичвэр, жишиг байршил.....	11
Зураг 8. Хаалгатай харьцуулан байрлуулах	11
Зураг 9. Самбарыг тогтоох хэсэг	12

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төрийн байгууллагын ангилал	6
Хүснэгт 2. Нэрийн тэмдгийн өнгө	6
Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт	12



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Г Гудамж, зам, барилга байгууламжийн
хаягжилтад хамаарах хотын стандартыг
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Гудамж, зам, барилга байгууламжийн хаягжилт” бүлэгт хамаарах UCS2101A:2023 “Төрийн байгууллагын нэрийн тэмдэг” хотын стандартыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Б.Мягмар)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100555

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ГУДАМЖ, ЗАМ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ

UCS 2101A:2023 “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДЭГ” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын нэрийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байрлуулах, суурилуулах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах журмын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.


- Хаягжуулалтын тухай хууль;
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт);
- Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай (ЗГ-ын 37-р тогтоол, 2013 он);
- Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага (Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт);
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт).

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Нэрийн тэмдэг - гэж байгууллагын нэрийг мэдээлэх зорилготой, зөвхөн нэр нь бичээстэй тэмдгийг хэлнэ.

4. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Төрийн байгууллага нь өөрийн нэрийн тэмдгийг байрлаж буй барилга, ажлын байрныхаа гадна талд төв хаалга, орцны орчимд иргэдэд ойлгомжтой, ил тод харагдах байдлаар байршуулна. (Зураг 1.)
- 4.2. Төрийн байгууллагын нэрийн тэмдэгт нь нэрийн бичвэр, билэгдэлийг агуулах бөгөөд бүтэн нэрийн бичвэр нь Монгол, англи хэлээр, Монгол үндэсний /уламжлалт монгол бичиг/ бичгээр бичигдсэн байна. Тэмдгийн дэвсгэр өнгө нь төрийн байгууллагын ангиллаас хамааруулан алтан шар, мөнгөлөг, хөх цэнхэр өнгөтэй байна.
- 4.3. Нэрийн тэмдгийг үйлдвэрлэхдээ нар, салхи, ус чийгт тэсвэртэй, элэгдэл даах сайн чанарын материал ашиглаж, бат бөх суурилуулна.



Зураг 1. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг (Жишээ зураг)

5. НЭРИЙН ТЭМДГИЙН БИЧВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Нэрийн тэмдэгт Сүлд, Соёмбо, Хангарди, байгууллагын билэгдэлийг дүрслэхдээ Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 17 дугаар тогтоолыг тус тус баримтална.



Зураг 2. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн бичвэр (Жишээ зураг)

- 5.2. Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд самбарын зүүн талд үндэсний бичгээр бичнэ.
- 5.3. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зах хоорондын зай 6 см байна. Бичвэрийн эхний мөрийг мөр тэтгэж бичих бөгөөд үгийн титэм, шилбэ, гэдэс, нум, орхиц, сүүл зэрэг зурлага нь өмнөх болон дараах мөрний үг, үсэгт тулахааргүй бичигдсэн байна.

- 5.4. Нэрийн тэмдгийн англи хэл дээрх бичвэр нь Монгол /кирилл/ бичвэрийн доор байрлах бөгөөд түүнээс хоёр дахин бага өндөртэй байна.
- 5.5. Байгууллагын нэрийн тэмдэгтийн тоо, хэмжээнээс шалтгаалан нэрийн бичвэрийн самбарын хэмжээ хамгийн ихдээ өндөр нь 70 см, өргөн нь 120 см байх ба нэрийн бичвэрийн үсгийн өндөр, үг, үсэг, билэгдлийн хоорондын зай, хэмжээг өөрчлөхгүй.

6. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ

- 6.1. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудыг дараах байдлаар ангилна. Үүнд:

Хүснэгт 1. Төрийн байгууллагын ангилал

№	Байгууллагын ангилал	Хамаарах байгууллагууд /Жишээ/
1	Дээд газар, Яам түүний харьяа газар	Сангийн яам ... гэх мэт
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллага, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
3	Дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага	Дүүргийн Засаг даргын тамгын газар, хэлтэс, алба, харьяа байгууллага

7. НЭРИЙН ТЭМДГИЙН ДЭВСГЭР ӨНГӨ

- 7.1. Нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгууллагын ангиллаас хамааруулан алтан шар, мөнгөлөг, хөх цэнхэр өнгөтэй байх бөгөөд дараах байдлаар авч хэрэглэнэ.

Хүснэгт 2. Нэрийн тэмдгийн өнгө

№	Байгууллагын ангилал	Нэрийн тэмдэгний өнгө	Өнгөний код
1	Дээд газар, Яам түүний харьяа газар		HTML /CSS/ Алтан шар, Metallic gold/ Hex Code #RRGGBB /#D4AF37/ Decimal Code R,G,B /212,175,55/
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд		HTML /CSS/ Хөх цэнхэр, blue Hex Code #RRGGBB /#0000FF/ Decimal Code R,G,B /0,0,255/
3	Дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага		HTML /CSS /Мөнгөлөг, Silver/ Hex Code #RRGGBB /#C0C0C0/ Decimal Code R,G,B /192,192,192/

8. ДЭЭД ГАЗАР, ЯАМНЫ НЭРИЙН ТЭМДГИЙН БИЧВЭР САМБАРЫН ХЭМЖЭЭ



Зураг 3. Алтан шар нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ (Жишээ зураг)

- 8.1. Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна.
- 8.2. Самбарын өндөр нь 45-70 см, өргөн нь 70-120 см, харьцаа нь $70/45=1.6$ буюу 1.6-1.9 хооронд байна.
- 8.3. Монгол кирилл бичвэрийг голлуулж дээд, дунд хэсэгт сүлд, билэгдлийг 13x13 см, соёмбыг 16x16 см хэмжээтэй байрлуулна.
- 8.4. Монгол кирилл үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр 4,5 см өндөртэй бүх үсгийг томоор бичнэ.
- 8.5. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зүүн зах хоорондын зай байгууллагын нэрийн тэмдэгтээс хамааран 5 см-ээс 6 см байна.
- 8.6. Монгол үндэсний бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байх бөгөөд юникод стандартын шрифтээр бичнэ.
- 8.7. Латин үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр Монгол кирилл бичиглэлээс 2 дахин бага хэмжээтэй байна.

9. НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

- 9.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллага, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагын нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээг Зураг 4-т үзүүлэв.



Зураг 4. Хөх цэнхэр нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ (Жишээ зураг)

- 9.2. Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна.
- 9.3. Самбарын өндөр нь 45-70 см, өргөн нь 70-120 см, харьцаа нь $70/45=1.6$ буюу 1.6-1.9 хооронд байна.
- 9.4. Монгол кирилл бичвэрийг голлуулж дээд, дунд хэсэгт сүлд, билэгдлийг 13x13 см, соёмбыг 16x16 см хэмжээтэй байрлуулна.
- 9.5. Монгол кирилл үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр 4,5 см өндөртэй бүх үсгийг томоор бичнэ.
- 9.6. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зүүн зах хоорондын зай байгууллагын нэрийн тэмдэгтээс хамааран 5 см-ээс 6 см байна.
- 9.7. Монгол үндэсний бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байх бөгөөд юникод стандартын шрифтээр бичнэ.
- 9.8. Латин үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр Монгол кирилл бичиглэлээс 2 дахин бага хэмжээтэй байна.

10. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

- 10.1. Дүүргийн Засаг даргын тамгын газар, хэлтэс, харьяа байгууллагын нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээг Зураг 5-т үзүүлэв.




Зураг 5. Мөнгөлөг нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ (Жишээ зураг)

- 10.2. Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна.
- 10.3. Самбарын өндөр нь 45-70 см, өргөн нь 70-120 см, харьцаа нь $70/45=1.6$ буюу 1.6-1.9 хооронд байна.
- 10.4. Монгол кирилл бичвэрийг голлуулж дээд, дунд хэсэгт сүлд, билэгдлийг 13x13 см, соёмбыг 16x16 см хэмжээтэй байрлуулна.
- 10.5. Монгол кирилл үсгийн хэвжүүлэлд *arial narrow* шрифтээр 4,5 см өндөртэй бүх үсгийг томоор бичнэ.
- 10.6. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зүүн зах хоорондын зай байгууллагын нэрийн тэмдэгтээс хамааран 5 см-ээс 6 см байна.
- 10.7. Монгол үндэсний бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байх бөгөөд юникод стандартын шрифтээр бичнэ.
- 10.8. Гадаад үсгийн хэвжүүлэлд *arial narrow* шрифтээр Монгол кирилл бичиглэлээс 2 дахин бага хэмжээтэй байна.

11. МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

- 11.1. Нэрийн тэмдгийн материал, дэвсгэр өнгө, бичвэр нь аливаа байгалийн үзэгдэлд тэсвэртэй, хуурч гандахгүй, зэвэрдэггүй өнгөт ган төмөр /нерж/ байх бөгөөд хамгаалалтын гадаргуутай байна.
- 11.2. Нэрийн тэмдгийн гадаргуугийн гэрлийг ойлгох чанар нь 70%-иас ихгүй байна.




Зураг 6. Нэрийн тэмдгийн гадаргуугийн гэрлийг ойлгох чанар (Жишээ зураг)

12. БАЙРЛУУЛАХ

- 12.1. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийг барилга байгууламжийн нүүрэн талд, нийтэд харагдахуйц байрлуулах бөгөөд орох, гарах хаалгатай ойролцоо байрлуулна.
- 12.2. Нэг барилга байгууламжид хэд хэдэн байгууллага, аж ахуй нэгж байрлан үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд байгууллагын нэрийг барилга байгууламжийн гадна болон дотор талд мэдээллийн самбарт байрлуулах бөгөөд байгууллагын нэрийн тэмдгийг үйл ажиллагаа явуулж буй давхарт, зөвхөн өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хаалганы гадна орох талын баруун гар талд байрлуулна.
- 12.3. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг байрлуулах жишиг загварыг Зураг 7, 8-т үзүүлэв.



Зураг 7. Төрийн байгууллагын нэрийн бичвэр, жишиг байршил (Жишээ зураг)



Зураг 8. Хаалгатай харьцуулан байрлуулах (Жишээ зураг)

13. СУУРИЛУУЛАХ

- 13.1. Нэрийн тэмдгийн самбарыг байрлуулах, суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангана.
- 13.2. Нэрийн тэмдгийг салхинд унахгүйгээр бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх бөгөөд олон нийтийн гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.



Тогтоож бэхлэх хэсэг

Зураг 9. Самбарыг тогтоох хэсэг (Жишээ зураг)

14. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДГИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэрийн тэмдгийн бичвэр, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох хүлээн авах шалгуур үзүүлэлт. (Хүснэгт 1.)

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Байгууллагын нэр тэмдгийн мэдээлэл тохирч байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Тэмдгийн бичвэр үг, үсгийн алдаагүй зай хэмжээний шаардлага хангаж байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Тэмдгийн хэмжээ стандартын шаардлага хангаж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Өнгө, гэрэл ойлголт стандарт шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Тэмдгийг зөв байршилд байрлуулсан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Тэмдгийн суурилуулалт бэхэлгээ шаардлага хангаж байгаа эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хаягжуулалтын тухай хууль;
- Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай (ЗГ-ын 37-р тогтоол, 2013 он);
- Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага (Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт);
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт).

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар